




А/хятадын солонгос үндэстэн/нь солонгос иргэнтэй гэрлэсэн. Нөхөр нь хэдэн жил гэр бүлдээ анхаарал тавиагүйгээр барахгүй суратгүй алга болсон байна. Үүний улмаас оршин суух визээ сунгуулж чадалгүй хууль бус иргэн болсон байна. Тэрээр гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандаж байх хугацаандаа цагаачлалын албаны шалгалтанд өртөн түүнийг албадан гаргах захирамж гарч 2004оны 5сард ХЭҮКд өргөдөл гаргасан байна. Азаар өргөдөл гаргасны дараахан шүүхээс нөхрийн буруугаас болж гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргасан байна. Энэ асуудлын талаар Хүний Эрхийн хороо нь солонгос нөхрийн буруугаас болж хууль бус иргэн болж, солонгосын иргэншил хүсэх боломжгүй болсон нь зүй бус хэрэг гэж үзээд Хууль Зүйн Яамны сайдад анхааралдаа авах тухай санал оруулсан болно.



В/этиоф/ нь 2008оны 2сард Итэвонд орших нэгэн хоолны газар орох гэсэнд үүдний ажилтан нь Африк хүн гэсэн шалтгаанаар орохыг хоригложээ. В нь ХЭҮКд ялгаварлан гадуурхагдсан тухай өргөдөл гаргасан байна. ХЭҮК нь улс үндэстнээр ялгаварлан гадуурхах асуудал нь тухайн албан газар байнга гардаггүй ба тухайн үед үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс гаргасан шаардлага боловч тус албан газраас Африк хүн учраас оруулаагүй гэдгийг батласан байна. Энэ тухай ХЭҮК нь Засгийн газрын нэгдэн орсон арьсны өнгөөр ялгаварлан гадуурхлын бүх хэлбэрийг халах тухай олон улсын хамтын гэрээний заалтыг зөрчсөн гэж үзэж тухайн албан газарт сануулга өгсөн болно.

Зөвлөгөө. Өргөдөл гаргах

Утас.: Солонгосын хаанаас ч 1331

Шуудан / Биеэр ирэх :

<p>서울 Сөүл хот</p>	<p>044551 서울시 중구 삼일대로 340 나라키움 저동빌딩 11층 04551 Сөүл хот Жүн-гү Самил-дэрү 340 Нара Киүм Жодун барилга 11 давхарт 47606 англи болон бусад хэлээр орчуулгын үйлчилгээ</p>
<p>부산 Бусан хот</p>	<p>611-705 부산광역시 연제구 중앙로 1992 국민연금부산회관 7층 611-705 Бусан хот ,Енжэ дүүрэг, жунанзу 1992, Нийгмийн даатгалын Бусан дахь барилга 7 давхарт Tel: 082-51-710-9710</p>
<p>광주 Гванжү хот</p>	<p>61476 광주광역시 동구 금남로 154-1 아모레퍼시픽 5층 61476 Гуанжу хот Дун-гү Кимнам-ру 154-1 Амурэ Пошипик ХК барилга 5 давхарт Tel: 082-62-710-9710</p>
<p>대구 Тэгү хот</p>	<p>700-732 대구광역시 중구 동인2가 50-3 호수빌딩 16층 700-732 Тэгү хот, жун дүүрэг, дунил 2га 50-3, хусү барилга 16 давхарт Tel: 082-53-212-7000</p>
<p>대전 Тэжон</p>	<p>35262 대전광역시 서구 문정로 48번길 30 KT탄방타워 13층 35262 Тэжон хот Со-гү Мүнжон-ру 48бон-гил 30 КТ Танбан барилга 13 давхарт Tel: 082-42-472-9037</p>

Вэб хаяг : www.humanrights.go.kr
Факс : 082-2-2125-9811~2
Имэйл хаяг : hoso@humanrights.go.kr

※ Баривчлагдан түр саатуулах байранд байгаа тохиолдолд тухайн газарт буй ХЭҮКд өргөдөл гаргах хайрцагийг ашиглаж өргөдөл хүсэлт гаргаж болно. Эсвэл тухайн газрын ажилтанд хандсан тохиолдолд ХЭҮКоос байцаагч очиж өргөдлийг хүлээн авна.

Байршил



Зүс царай өөр ч эдлэх эрх нь адил



Хүн төрөлхтөн бүгдээрээ хамгаас эрхэм



Үйлдвэрлэл эрхлэгч Сийн үйлдвэрт цагаачлалын албаны ажилтнууд албан ёсны зөвшөөрөлгүй дайран орж хууль бус ажилчдыг баривчлахыг хараад ажил олгогч С нь гадаадын ажилчин ч эрхээ хамгаалах ёстой гээд ХЭҮКд хандсан байна. 2005оны 12сард ХЭҮКоос Сийн гаргасан гомдлыг үндэслэлтэй хэмээн хүлээн зөвшөөрч гадаад ажилчдын эрх ийнхүү зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж Хууль зүйн яамны сайдад барилга байшинд халдан ороход хууль зүйн үндэслэл тогтоож өгөхийг хүссэн байна.



D/орос/ 2002оны 9сард ХЭҮКд хандсанаар нутаг буцах тухай асуудлаа шийдүүлсэн байна. Тэрээр эхнэрийг нь чангаасан согтуу Солонгос иргэнийг хориглон түүнтэй зодолдсон байна. Үүний улмаас 3 сар орчим эмчлүүлэх гэмтэл авсан боловч хууль бус ажилчин гэсэн шалтгаанаар түүнд цагаачлалын албанаас албадан нутаг буцаах захирамж гарчээ. Сүмийн ажилтан түүний өмнөөс ХЭҮКд өргөдөл гаргаснаар асуудлыг шийдэж эргэн ажлаа хийх боломжтой болсон байна.



Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)

• танд хамгийн ойрхон таны эрхийг хамгаалах байгууллага

Хүний эрх зөрчигдөх, хүүль бусаар ялгаварлан гадуурхагдах явдлын улмаас хохирсон аливаа хүн, түүнчлэн үүнийг мэдсэн гуравдагч этгээд хохирсон хүний өмнөөс бидэнд гомдол гаргаж болно.

• үнэ төлбөргүй

шүүхэд нэхэмжлэл гаргахаас ялгаатай ба зөвлөгөө авах, гомдол гаргах, эрхээ хамгаалахад ямар ч зардал гарахгүй. Энэ бол таны эрхээ хамгаалах хамгийн хямд төсөр, хамгийн үр дүнтэй арга зам юм.

Ямар тохиолдолд эрхээ хамгаалуулж болох вэ?

• ХЭҮК хүний эрхийн зөрчлийг арилгаж урьдчилан сэргийлнэ.

Улсын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, цэргийн болон хууль сахиулах байгууллага, сургууль, хорих болон саатуулах газрууд албан үүргээ гүйцэтгэх явцдаа таны эрхийг зөрчвөл ХЭҮК-д хандана уу.

• Таныг ялгаварлан гадуурхаж байна уу? ХЭҮК-д хандаарай

Үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхсан бүх үйлдэл : нас, хүйс, боловсрол, төрсөн нутаг, үндэс угсаа, арьсны өнгө, өвчин, гэр бүл зохиосон эсэх
※ ХЭҮК хүйсийн ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтад онцгой анхаарал тавьдаг.

ХЭҮК таны байгаа газарт очно!

Цагдан хорих буюу саатуулах газарт хоригдож буй иргэд ХЭҮК-ын байцаагчтай уулзаж өргөдөл гаргах эрхтэй. Хоригдож буй иргэн өргөдөл гаргахыг хүсвэл тухайн цагдан хорих, саатуулах газар шаардлагатай нөхцөлөөр хангах ёстой. Шалгалтыг зүй ёсны дагуу явуулахад саад учруулсан тохиолдолд хүний эрхийг хамгаалахад саад учруулсан хэргээр шийтгэнэ.

Яаралтай арга хэмжээ авах

ХЭҮКээс өргөдлийг шалгах явцад эсвэл өргөдөл гаргаагүй ч хүний эрх байнга, ноцтойгоор зөрчигдсөөр байгаа нь тогтоогдвол яаралтай арга хэмжээ авна.

- Эмчилгээ, хоол хүнс, хувцас хунараар хангана.
- Хоригдож буй хүнийг шаардлагатай тохиолдолд өөр хорих газар луу шилжүүлэх
- Хүний эрх зөрчсөн эсвэл ялгаварлан гадуурхах үйлдэл хийсэн нь тогтоогдсон төрийн албаны ажилтанг төрийн албанаас гаргах хүртэл арга хэмжээ авна.

Гарчиг. Хууль тогтоомж ба эрх зүйн актын шинэчлэлт өөрчлөлтөнд санал оруулах

Гадаадын ажилчин болон ажиллах хүчний тогтолцоонд өөрчлөлт шинэчлэл оруулах, хилээр нэвтрэх болон хилээр орж гарахтай холбоотой хуулинд өөрчлөлт шинэчлэл оруулах, олон соёлт гэр бүлийг дэмжих хууль ба гэр бүл зуучлах хуулинд санал оруулах зэрэг ХЭҮК нь солонгос улсад оршин сууж буй гадаадын иргэдийн эрхийг хамгаалахын тулд хууль тогтоомж, эрх зүйн бодлого шинэчлэлтэнд санал оруулдаг болно. Үүний тулд гадаадын ажилчин, цагаач иргэн, гадаад хүүхэд, дүрвэн ирж буй иргэдийн хүний эрхийн байдлыг судлан мэргэжлийн хүмүүстэй хамтран төрөл бүрийн хэлэлцүүлгүүдийг явуулдаг юм.

Гарчиг. Олон үндэстний хүний эрхийн сургалт ба гадаадтай хамтарсан үйл ажиллагаа

Солонгос улсад амьдарч буй гадаад иргэдийн эрх ашгийг хамгаалахын тулд нийгэм дэх үзэлд өөрчлөлт шинэчлэлт хийх нь чухал юм. ХЭҮК нь цагаачлалын албаны ажилтан, олон соёлт гэр бүлийг дэмжих төвийн ажилтан, гадаад ажилчин, ажил олгогч нарыг хамарсан байнгын сургалт явуулж байна. Түүнчлэн ХЭҮК-оос “6 төрлийн харц” нэртэй киног бүтээж солонгосын нийгэм дэх ялгаварлан гадуурхах үзлийг өөрчлөхөөр зорьж байна. Жил бүр хүний эрхийн байгууллагуудтай хамтарч гадаадын цагаач иргэдийн эрх ашгийг хамгаалах, НҮБ-ын ХЭҮК-ын Зөвлөлтэй хамтарч Азийн хүний эрхийн байгууллагаар дамжуулан хүний эрхийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.



ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ШАТ ДАРААЛАЛ

